



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/13/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2020 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Ахлах аудитор: О.Нарангарав Утас: 70523020 Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө	7
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Бараа материал	8
2.8.4 Үндсэн хөрөнгө	9
2.8.5 Өр төлбөр	9
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

1. Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.03.18 № 1-6/335

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ц.ЭРХЭМБОЛД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010029159

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ТТЗ-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Эрхэмболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 05-аас 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/66 дугаар бүхий албан бичгээр 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн

Улаанбадрах сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллага, сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улаанбадрах сумын ТТЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэл санхүүгийн тайлангийн цэвэр хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг цэвэр хөрөнгийн 4,268.0 сая төгрөгийн 1 хувь буюу 42.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 49.2 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үед материаллаг байдлыг 2019 оны хагас жилийн тайлангийн дүнгээр сонгон авсан тул өөрчлөн жилийн эцсийн тайлангаар материаллаг байдлыг тодорхойлсонтой холбоотой.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 төсвийн байгууллага 2 тусгай сан аудитад хамрагдсан байна. Төсвийн 3 байгууллагад санал дүгнэлт өгөхөөр, төсвийн 3 байгууллага болон 2 сангийн санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дараах дүгнэлтүүдийг өгсөн байна.

- “**Зөрчилгүй**” дүгнэлтийг - Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг
- “**Хязгаарлалттай**” дүгнэлтийг - Ерөнхий боловсролын сургууль

Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 329.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 250.1 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулав.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн 66.8 сая төгрөгийн зөрчил нь Улаанбадрах сумын ТТЗ-ийн нэгтгэл тайлангийн тоон үзүүлэлтээр тооцсон материаллаг байдалд нөлөөлж байгаа боловч уг зөрчлийг аудитын явцад залруулан бүртгэх боломжтой НББ-ийн алдаа байсан тул шинж чанарын хувьд материаллаг байдалд нөлөөлөхгүй гэж үзсэн болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн 185.3 сая төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд үндсэн хөрөнгийн дансыг 3.4 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 181.9 сая төгрөгөөр хөрөнгийн зардлыг хангамжийн материалын зардалд нэгтгэсэн;

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 64.8 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- ОНХС-ийн санхүүгийн тайланд 50.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг зардлаар бүртгэсэн бүртгэлийг дуусаагүй барилга дансанд залруулан бүртгэв.
- Сумын Засаг даргын тамгын газрын тайланд 14.3 сая төгрөгийн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцсон, хөрөнгийг буруу ангилалд бүртгэсэн болон данс хөтлөлтийн алдааг залруулан бүртгэсэн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн зөрчлийг нэгтгэн хавсралт 1-ээр үзүүлсэн болно.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 81.8 сая, эцсийн үлдэгдэл 105.4 сая төгрөг болж, 23.6 сая төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	81.80	105.40	23.60	28.85
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	81.80	105.40	23.60	28.85

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байгаа 105.4 сая төгрөгийн 0.1 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 6.0 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, 94.6 сая төгрөг СХС-ийн дансанд, 4.7 сая төгрөг нь байгаль орчны нөхөн сэргээх сангийн-ийн дансанд тус тус байршиж байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 154.8 сая, эцсийн үлдэгдэл 131.9 сая төгрөг болж, 22.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.4		(0.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-		-
Татаас, санхүүжилтийн авлага	-		-
Зээлийн хүүгийн авлага	-		-
Бусад авлага	0.5		(0.5)
Зээлийн авлага	153.9	131.9	(22.0)
Дүн	154.8	131.9	(22.9)

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 22.9 сая төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой болон бусад авлагын өмнөх оны авлагын үлдэгдэл бүрэн барагдаж, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 22.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 131.9 сая төгрөг нь СХС-ийн зээлийн авлага байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 237.8 сая, эцсийн үлдэгдэл 275.7 сая төгрөг болж, 37.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Тусгай зориулалттай материал	61.29	64.77	3.48
Эм боох материал	0.51	9.58	9.07
Бичиг хэргийн материал	5.28	8.10	2.82
Аж ахуйн материал	40.72	45.97	5.26
Барилгын засварын материал	-	-	-
Сэлбэг хэрэгсэл	-	0.84	0.84
Түлш шатах тослох материал	26.73	31.87	5.14
Хүнсний материал	8.36	12.05	3.69
Бусад хангамжийн материал	92.67	97.84	5.18
Мал амьтад	2.29	4.71	2.42
Дүн	237.83	275.73	37.90

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 37.9 сая төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудын тусгай зориулалтын материал 3.5 сая төгрөг, эм боох материал 9.1 сая төгрөг, бичиг хэрэг 2.8 сая төгрөг, аж ахуйн материал 5.3 сая төгрөг, түлш шатах тослох материал 5.1 сая төгрөг, хүнсний материал 3.7 сая төгрөг, мал амьтанд 2.4 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл болон бусад хангамжийн материал 6.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Мөн харьяа байгууллагуудын дээд шатны төсвийн захирагчдаас үнэ төлбөргүйгээр материал нийлүүлсэн нь нөлөөлөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулагдсан материал байгаа бөгөөд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,683.7 сая, эцсийн үлдэгдэл 4,405.9 сая төгрөг болж, 722.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,583.21	4,305.47	722.26
Барилга, байгууламж	2,564.84	3,183.03	618.19
Хуримтлагдсан элэгдэл	(4.72)	(73.31)	(68.59)
Авто тээврийн хэрэгсэл	282.02	308.42	26.41
Хуримтлагдсан элэгдэл	(184.72)	(199.48)	(14.75)
Машин тоног төхөөрөмж	406.63	450.28	43.65
Хуримтлагдсан элэгдэл	(264.61)	(302.86)	(38.25)
Тавилга, аж ахуйн эд хогшил	184.53	183.02	(1.51)
Хуримтлагдсан элэгдэл	(134.30)	(135.83)	(1.53)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2.54	2.54	-
Бусад үндсэн хөрөнгө	948.80	1,081.48	132.67
Хуримтлагдсан элэгдэл	(237.53)	(270.40)	(32.87)
Дуусаагүй барилга	-	50.00	50.00
Номын фонд	19.74	28.59	8.85
Биет бу хөрөнгө	100.48	100.41	(0.07)
Программ хангамж	3.61	2.01	(1.59)
Хуримтлагдсан элэгдэл	(3.26)	(1.73)	1.52
Бусад биет бус хөрөнгө	100.13	100.13	-
Дүн	3,683.69	4,405.88	722.19

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд харьяа төсөвт байгууллагууд 79.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, 35.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, УТХО болон ОНТХО, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 821.8 сая төгрөг, нийт 936.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгдэж, балансаас балансад 35.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 24.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох журмын дагуу актлан данс бүртгэлээс хассан байна.

Дуусаагүй барилга дансанд ОНХС-аас хийгдэж буй бохир усны байгууламжийн дуусаагүй ажил 50.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.2 сая, эцсийн үлдэгдэл 0.08 сая төгрөг болж, 2.1 сая төгрөгөөр буюу 96.5 хувиар буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	2.23	0.08	(2.16)	96.51
<u>Ажиллагсадтай холбогдсон өглөг</u>	1.49	-	(1.49)	100.00
<u>Байгууллагат төлөх өглөг</u>	0.52	0.08	(0.44)	85.05
<u>Хувь хүмүүст төлөх өглөг</u>	0.22	-	(0.22)	100.00
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	-	-	-	-
Нийт дүн	2.23	0.08	(2.16)	96.51

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 2.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөр бүрэн барагдаж дууссантай холбоотой байна. Оны эцсийн 78.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл нь төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн үлдэгдлийг төвлөрүүлэлтээс үүссэн байна.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Цэвэр хөрөнгө өмчийн дансны эхний үлдэгдэл 4,155.9 сая, эцсийн үлдэгдэл 4,918.8 сая төгрөг болж, 762.9 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	2,122.96	2,122.96	-	-
/ЗГсан/ орон нутгийн сан				
Өмч:Төрийн өмч	2,122.96	2,122.96	-	-
Хуримтлагдсан үр дүн	408.45	1,171.97	763.52	186.93
Өмнөх үеийн үр дүн	408.45	409.06	0.61	0.15
Тайлант үеийн үр дүн	-	762.91	762.91	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,624.53	1,623.92	(0.61)	(0.04)
Дүн	4,155.95	4,918.85	762.91	18.36

Эх сурвалж: Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл 762.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд харьяа 2 төсөвт байгууллагад нийт 0.6 сая төгрөгийн НББ-ын бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдсэн байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2018 оны А/46, 2019 оны 13-р тогтоолуудад орон нутгийн төсөвт төвлөрүүлэх сумын татварын болон татварын бус орлогыг 30.5 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 40.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 32.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /илүү +, дутуу - /	Хувь
Үйл ажиллагааны орлогын татвар	1,721.50	2,384.80	663.30	38.53
Бусад орлогын татвар/Хувь хүнээс суутгасан ОАТ	9,110.70	16,307.78	7,197.08	79.00
Хадгаламж хүү	12,107.50	15,830.97	3,723.47	30.75
Хөрөнгө борлуулсны орлого	250.00	-	(250.00)	- 100.00
Бууны татвар	2,310.00	2,250.00	(60.00)	- 2.60
УТХураамж	930.10	1,199.78	269.68	29.00
Хог хаягдлын хураамж	3,936.00	2,340.50	(1,595.50)	- 40.54
ТТАМАТөлбөр	10.00	50.00	40.00	400.00
Бусад орлого /хүү торгууль/	150.00	100.56	(49.44)	- 32.96
Дүн	30,525.80	40,464.39	9,938.59	32.56

Сумын татварын болон татварын бус орлого 9.9 сая төгрөгөөр давж биелэхэд үйл ажиллагааны орлогын татвар 0.7 сая төгрөг, бусад орлогын татвар 7.2 сая төгрөг, хүүгийн орлогын татвар 3.7 сая төгрөг, УТХ болон ТТАМАТ 0.3 сая төгрөгөөр тус тус давж, хөрөнгө борлуулсны орлого 0.2 сая төгрөг, хог хаягдлын хураамж 1.6 сая төгрөг, бууны татвар болон бусад хүү торгуулийн орлого 0.1 сая төгрөгөөр тус тус тасалдсан нь шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,912.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,525.2 сая төгрөгийг урсгал зардалд, 387.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 533.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 838.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 15.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 387.6 сая төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээс, 73.0 сая төгрөгийг нөхөн сэргээх болон СХС-ийн оны эхний үлдэгдлээс, 65.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 09/08 дугаар тогтоолоор суманд олгох татаас санхүүжилтийг 350.9 сая төгрөгөөр баталсныг 2019 оны 12/07 тогтоолоор 397.6 сая төгрөгөөр буюу 46.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 533.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 838.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 13.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 232.3 сая төгрөгийг ОНХС-ийн санхүүжилтээс, нийт 1,617.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. ОНХС-ийн санхүүжилтийг 155.4 сая төгрөгөөр, ЭМДС-аас 1.6 сая төгрөгийг тус тус дутуу олгосон байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын 107.9 сая төгрөг нь батлагдсан төсвөөс 42.4 сая төгрөгөөр давсан байна. Энэ нь СХС-ийн зээлийн эргэн төлөлт 46.0 сая төгрөгөөр давж, НСС-ийн орлого 3.6 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,613.1 сая төгрөг буюу 84.3 хувьтай байгаа нь урсгал зардлын зардлын гүйцэтгэл 1,380.9 сая төгрөг, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 232.1 сая төгрөг байгаатай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг зардлын зүйлээр авч үзвэл: Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 989.0 сая төгрөг нь нийт зардлын 61.3 хувь, бараа ажил үйлчилгээний бусад зардал 376.4 сая төгрөг нь нийт зардлын 23.3 хувь, урсгал шилжүүлгийн зардал 15.5 сая төгрөг нь нийт зардлын 0.9 хувийг тус тус эзэлж байна.

Хөрөнгө оруулалтын зардлын ОНХС-аас санхүүжих 4 төсөл, арга хэмжээнд 387.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 232.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төлөвлөгөөний дагуу 2 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 ажил үйлчилгээ

хагас хэрэгжиж хэрэгжсэн дүнгээр санхүүжилтийг олгосон байна. Мөн 1 ажил үйлчилгээнд урьдчилгаа санхүүжилт олгож дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Жилийн эцэст урсгал зардлын хэмнэлт 88.7 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 3 байгууллагад 6.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын хүрээнд 3 байгууллагад 43.7 сая төгрөг, нийт 50.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Тухайлбал:

- Сумын ЗДТГ-т аймгийн Онцгой байдлын газраас малын нөхөн төлбөр болон томилолтын зардлын санхүүжилт 16.6 сая төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардлын санхүүжилт 2.2 сая төгрөг, АИТХ-аас олон нийтийн цагдаагийн урамшуулал болон тойрогт ажиллах зардлын санхүүжилт 8.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны давсан орлого 2.0 сая төгрөг, өвс тэжээлийн болон буудлын орлого 16.1 сая төгрөг нийт 44.9 сая төгрөгийг

- Сумын ЕБС-ийн заалны түрээсийн орлого 2.2 сая төгрөг, ЭМТ-д дээд шатны төсөв захирагчаас 0.9 сая төгрөгийг шилжүүлснийг холбогдох дансны ангилалд тус тус бүртгэсэн байна.

Нийт санхүүжилтийн зарцуулах эрхийг зохих журмын дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээр нээлгэн холбогдох бараа үйлчилгээний зардалд 49.8 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Жилийн эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 550.0 төгрөгийг ЕБС-аас сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ТТЗ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 127 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ТТЗ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	474,491.42	513,053.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	81,790.94	105,367.91
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	81,790.94	105,367.91
31210	Төгрөг	81,790.94	105,367.91
31211	Төрийн сангийн харилцах	81,790.94	105,367.91
33	АВЛАГА	154,868.44	131,953.40
33500	Бусад авлага	529.71	0.00
33510	Байгууллагаас авах авлага	357.59	0.00
33600	Зээлийн авлага	153,919.75	131,953.40
